



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2018 оны 04 сарын 18 өдөр


Дугаар A/145

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.



САЙД

Д.САРАНГЭРЭЛ

080661

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 04 сарын 12-ны өдрийн
дугаар тушаалын 1 дугаар хавсралт

А/145

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖЛИЙН МЭРГЭШЛИЙН ЧИЛГЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшшлийн чиглэл	Зөвшөөрлийн лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Майкл Жон Metro	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ00001911	Бөөрний мэс засал судлал	Эмчлэх	2018.04.28-2018.05.05 /8 хоног/
2.	Ён Так Ли	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	ГЭ00001912	Зүрх, судасны мэс засал судлал	Эмчлэх	2018.04.18-2018.04.24 /7 хоног/
3.	Петти Жон Кеннет Petty John Kenneth	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ00001913	Хүүхдийн мэс засал судлал	Эмчлэх	2018.04.16-2018.04.24 /9 хоног/
4.	Жон Брэнсон Алберти John Brannon Alberty	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ00001914	Хүүхдийн хоол боловсруулах топтолцоо судлал	Эмчлэх	2018.04.16-2018.04.24 /9 хоног/
5.	Дикерсон Раян Дэвид Dickerson Ryan David	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ00001915	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	2018.04.16-2018.04.24 /9 хоног/

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 04. сарын 18.-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

A/145

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ШАЛТГААНД ТӨНЦСЕН
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖЛИЙН НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Myn Son Hu Moon Seong Ho	Бугд Найрамдах Солонгос Улс	Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв	ГЭ00001916	Уламжлалт анагаах судлал	Эмчлэх	1 жил
2.	Чой Мин Ёп Choi Minyoup	Бугд Найрамдах Солонгос Улс	"Си Эл Даблью Эйч" ХХК-ийн "Си Эл Даблью Эйч" эмнэлэг	ГЭ00001917	Эх барих, эмэгтэйчүүд судлал /Үргүйдэл судлал/	Эмчлэх	1 жил